



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/66

Улаан-Уул

Хязгаарлалтын дэглэм
тогтоох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын Бурхант 1 дүгээр багийн малчин Д.Батболд нь малын гоц халдварт үхрийн арьс товруутах өвчин гарсан Дорнод аймгийн Халх гол сумаас зөвшөөрөлгүйгээр мал амьтнаа тээвэрлэн 1 дүгээр багийн нутаг Товгор дэрс гэдэг газарт ирсэн тул тухайн нутаг дэвсгэрт 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 14 хоногоор хязгаарлалтын дэглэмийг тогтоосугай.

2.Тухайн малчны мал сүрэгт үзлэг хийх, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан ажиллах, нутаг дэвсгэрийн хүн амд зарлан мэдээлэх, хүн, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (А.Сүхээ), Мал эмнэлгийн улсын байцаагч (О.Намжирмаа), Хөдөө аж ахуйн тасгийн (О.Энхболд), сумын Хэсгийн цагдаа (Б.Өнөболд), багийн Засаг дарга (С.Лувсанцэрэн) нарт даалгасугай.

3.Хязгаарлалтын дэглэмтэй тогтоосонтой холбогдон гарах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг Тамгын газрын дарга (М.Зоригт), нягтлан бодогч (Ч.Батдорж) нар зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж цагийн байдлыг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (О.Намжирмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201115